



### ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн болон анагаах ухааны бусад сэтгүүлд 2-оос доошгүй илтгэл эсвэл өгүүлэл нийтлүүлсэн байх /илтгэл, өгүүллийн хуулбарыг сэтгүүл, номын нүүрийн хамт хувилж хавсаргана/;
2. Мэргэжлийн нийгэмлэгийн үйл ажиллагаанд тасралтгүй, идэвхтэй оролцдог байх;
3. Мэргэшлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан гаргах;
4. Ажиллах хугацааны сүүлийн 3-аас доошгүй жилд өөрийн эмнэлэг дээр залуу эмч, резидент эмч нарыг дагалдуулж сургасан байх /8 жилийн ажлын тайланд оруулах/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэжлийн болон анагаах ухааны бусад сэтгүүлд 4-өөс доошгүй илтгэл эсвэл өгүүлэл нийтлүүлсэн байх /илтгэл, өгүүллийн хуулбарыг сэтгүүл, номын нүүрийн хамт хувилж хавсаргана/;
2. Мэргэжлийн нийгэмлэгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд идэвхитэй оролцсон байх;
3. Мэргэшлээрээ ажилласан сүүлийн 5 жилийн ажлын тайлан ирүүлсэн байх;
4. Сүүлийн 5 жилд залуу эмч, резидент эмч нарыг дагалдуулж сургасан байх /5 жилийн ажлын тайланд оруулах/;
5. Нийгэмлэгээс зохион байгуулсан сургалт, семинарт лекц уншсан байх, эрдэм шинжилгээний хурал, чуулганд 5-аас доошгүй удаа илтгэл хэлэлцүүлсэн байх /5 жилийн ажлын тайланд оруулах/.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Бүтээлийн жагсаалт гаргах, нийтдээ 5-аас доошгүй өгүүлэл, 20-иос доошгүй илтгэл нийтлүүлсэн байх;
2. Мэргэшлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан ирүүлсэн байх;
3. Мэргэшлийн чиглэлээр мэргэжил арга зүйн бодлогын баримт бичиг (2-оос доошгүй) боловсруулсан, эсвэл боловсруулахад оролцсон байх.